

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/68/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Төлбөрийн акт	13
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 112

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Татварын тодорхойлолтоор өртэй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, чиг үүргийн биш ажилд төсвөөс хөрөнгө зарцуулсан, төсвийн зориулалт бусаар зарцуулсан, бодитоор ажиллаагүй албан тушаалтанд ажилласан мэтээр баримт бүрдүүлж цалин олгосон зэрэг 22.1 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020319

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
БУРГАСТАЙ ДАХЬ ГААЛИЙН
ХОРООНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ЭРДЭНЭСҮХ ТАНАА

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,643,986.00	9,752,396.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,643,986.00	9,752,396.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	956,500.00	956,500.00
35400	Хангамжийн материал	3,687,486.00	8,795,896.00
35420	Аж ахуйн материал	2,495,000.00	3,899,050.00
35470	Бусад хангамжийн материал	1,192,486.00	4,896,846.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,439,979,321.16	2,357,231,193.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,439,979,321.16	2,357,231,193.43
39200	Биет хөрөнгө	1,795,892,974.16	1,713,144,846.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,509,766,664.48	1,532,566,664.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	-147,246,103.40	-179,994,521.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	276,618,835.00	229,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-112,509,112.65	-93,727,777.66
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	378,942,542.45	383,280,742.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	-115,085,069.37	-177,008,557.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,796,802.73	33,821,052.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,391,585.08	-14,992,756.04
39300	Биет бус хөрөнгө	644,086,347.00	644,086,347.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	645,122,219.11	645,122,219.11
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,035,872.11	-1,035,872.11
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,444,623,307.16	2,366,983,589.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,444,623,307.16	2,366,983,589.43
51	Засгийн газрын хувь оролцоо	2,444,623,307.16	2,366,983,589.43
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,423,687,200.27	1,423,687,200.27
51200	Хуримтлагдсан үр дүн	532,179,767.13	454,540,049.40
51210	Өмнөх үеийн үр дүн	238,048,657.43	532,179,767.13
51220	Тайлант үеийн үр дүн	294,131,109.70	-77,639,717.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	488,756,339.76	488,756,339.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,444,623,307.16	2,366,983,589.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	907,329,905.18	599,986,210.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	342,292,505.18	17,007,310.00
120	Нийтлэг татварын бус орлого	342,292,505.18	17,007,310.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	338,654,741.18	12,481,200.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,637,764.00	4,526,110.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	565,037,400.00	582,978,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	565,037,400.00	582,978,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	565,037,400.00	582,978,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	613,198,795.48	677,598,427.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	613,198,795.48	677,598,427.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	610,319,322.79	551,818,595.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,986,826.86	280,673,545.90
210101	Үндсэн цалин	155,017,202.86	206,306,022.27
210102	Нэмэгдэл	69,908,340.94	36,647,666.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,661,286.51	14,729,471.33
210104	Урамшуулал	23,399,996.55	22,990,385.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,373,365.45	36,504,364.60
210201	Тэтгэврийн даатгал	32,373,365.45	36,504,364.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,904,068.00	35,333,047.68
210301	Гэрэл, цахилгаан	96,272,850.00	2,879,517.68
210302	Түлш, халаалт	74,662,650.00	27,438,034.00
210303	Цэвэр, бохир ус	4,968,568.00	5,015,496.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,491,500.00	25,757,610.00
210401	Бичиг хэрэг	2,982,600.00	2,982,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,666,000.00	9,998,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	985,000.00	985,000.00
210404	Ном, хэвлэл	0	10,220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	857,900.00	1,571,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,420,000.00	33,122,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	372,300.00	1,297,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,929,800.00	17,235,200.00
210604	Урсгал засвар	28,117,900.00	14,589,950.00
2107	Томилолт, зочны зардал	1,670,500.00	1,600,000.00
210702	Дотоод албан томилолт	1,670,500.00	1,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,174,067.00	3,416,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,319,500.00	873,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	780,000.00	780,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	504,667.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50,000.00	133,900.00
210807	Газрын төлбөр	0	160,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,431,900.00	1,376,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,298,995.48	135,410,577.73
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,298,995.48	135,410,577.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,879,472.69	125,779,831.82
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,879,472.69	125,779,831.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,879,472.69	125,779,831.82
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	294,131,109.70	-77,612,217.73
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	27,500.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	27,500.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	294,131,109.70	-77,639,717.73

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /	
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,423,687,200.27	488,756,339.76	238,048,657.43	2,150,492,197.46	
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,423,687,200.27	488,756,339.76	238,048,657.43	2,150,492,197.46	
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00	
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	294,131,109.70	294,131,109.70	
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,423,687,200.27	488,756,339.76	532,179,767.13	2,444,623,307.16	
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,423,687,200.27	488,756,339.76	532,179,767.13	2,444,623,307.16	
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,423,687,200.27	488,756,339.76	532,179,767.13	2,444,623,307.16	
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00	
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00	
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-77,639,717.73	-77,639,717.73	
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,423,687,200.27	488,756,339.76	454,540,049.40	2,366,983,589.43	

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	565,037,400.00	582,978,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	565,037,400.00	582,978,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	565,037,400.00	582,978,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	565,037,400.00	582,978,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	545,899,800.00	542,797,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	545,899,800.00	542,797,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,020,327.31	417,017,818.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,545,515.15	280,673,549.18
210101	Үндсэн цалин	155,017,202.88	206,306,022.27
210102	Нэмэгдэл	69,908,340.94	36,647,666.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,219,974.78	14,729,471.33
210104	Урамшуулал	23,399,996.55	22,990,389.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,814,677.16	36,504,361.32
210201	Тэтгэврийн даатгал	24,881,700.00	27,581,640.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,311,200.00	1,860,523.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,849,000.00	2,476,706.15
210204	Ажилгүйдлийн даатгал	462,200.00	416,781.13
210205	Эрүүл мэндийн даатгал	4,310,577.16	4,168,710.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,904,068.00	35,333,047.68
210301	Гэрэл, цахилгаан	107,657,700.00	2,879,517.68
210302	Түлш, халаалт	63,277,800.00	27,438,034.00
210303	Цэвэр, бохир ус	4,968,568.00	5,015,496.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,491,500.00	26,043,610.00
210401	Бичиг хэрэг	2,982,600.00	2,982,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,666,000.00	9,998,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	985,000.00	985,000.00
210404	Ном, хэвлэл	0	10,220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	857,900.00	1,857,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,900,100.00	33,446,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	302,400.00	2,402,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,626,400.00	15,425,200.00
210604	Урсгал засвар	27,971,300.00	15,618,750.00
2107	Томилголт, зочны зардал	1,670,500.00	1,600,000.00
210702	Дотоод албан томилолт	1,670,500.00	1,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,693,967.00	3,416,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,769,500.00	873,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	780,000.00	780,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	504,667.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	69,900.00	133,900.00
210807	Газрын төлбөр	50,000.00	160,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,431,900.00	1,376,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,879,472.69	125,779,831.82
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,879,472.69	125,779,831.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,879,472.69	125,779,831.82
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,137,600.00	40,181,250.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,137,600.00	40,181,250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,137,600.00	40,181,250.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,137,600.00	40,181,250.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,137,600.00	40,181,250.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-19,137,600.00	-40,181,250.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан / төгрөгөөр /
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	582,978,900.00	457,199,068.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	582,978,900.00	457,199,068.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582,978,900.00	457,199,068.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,472,700.00	280,673,549.18
210101	Үндсэн цалин	218,100,000.00	206,306,022.27
210102	Нэмэгдэл	71,827,200.00	36,647,666.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,945,500.00	14,729,471.33
210104	Урамшуулал	26,600,000.00	22,990,389.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,971,000.00	36,504,361.32
210201	Тэтгэврийн даатгал	45,262,300.00	27,581,640.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,873,400.00	1,860,523.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,683,500.00	2,476,706.15
210204	Ажилгүйдлийн даатгал	468,300.00	416,781.13
210205	Эрүүл мэндийн даатгал	4,683,500.00	4,168,710.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,952,800.00	35,333,047.68
210301	Гэрэл, цахилгаан	17,652,000.00	2,879,517.68
210302	Түлш, халаалт	63,277,800.00	27,438,034.00
210303	Цэвэр, бохир ус	5,023,000.00	5,015,496.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,825,500.00	26,043,610.00
210401	Бичиг хэрэг	2,982,600.00	2,982,600.00
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	9,998,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	985,000.00	985,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	10,220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,857,900.00	1,857,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	69,828,800.00	69,827,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,402,400.00	11,283,650.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,426,400.00	15,425,200.00
210604	Урсгал засвар	52,000,000.00	43,118,750.00
2107	Томилолт, зочны зардал	1,600,000.00	1,600,000.00
210702	Дотоод албан томилолт	1,600,000.00	1,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,328,100.00	7,216,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,704,000.00	4,673,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	780,000.00	780,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	794,800.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	133,900.00	133,900.00
210807	Газрын төлбөр	219,400.00	160,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,596,000.00	1,376,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	582,978,900.00	457,199,068.18
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	582,978,900.00	457,199,068.18
310001	Улсын төсвөөс санхүүжих	582,978,900.00	457,199,068.18

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хороо нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэх зорилготой байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжоос Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан босго үнэ өөрчлөгдсөнөөс өөр өөрчлөлт ороогүй, тус байгууллагын баримталдаг бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хороо нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал болох 613.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал болох 613.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр тооцсон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3 хувиар буюу 77.6 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд улсын төсвөөс 582.9 сая төгрөгийн санхүүжилт авч оны эцэст 125.8 сая төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн буюу 2021 оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9.7 сая төгрөг болж 5.1 сая төгрөгөөр өссөн. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 69.2 сая төгрөгийн, 4.5 сая төгрөгийн хамгаалах хэрэгсэл Гаалийн ерөнхий газраас ирж үйл ажиллагаандаа 68.6 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,824.4 сая төгрөг болж 3.3 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 40.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 3.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг Гаалийн ерөнхий газраас шилжүүлэн авч, 9.4 сая төгрөгийн өмнөх онд акталсан хөрөнгийг үнэ тогтоон бүртгэж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 346 дугаар албан бичгээр 55.9 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан данс бүртгэлээс хасжээ. Тайлант онд үндсэн хөрөнгөд 135.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,366.9 сая төгрөг болж 77.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн хаасан бичилт хийгээгүй. Тайлант онд хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 454.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 636.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 53.9 сая төгрөгөөр бууруулж, 582.9 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь урсгал зардал нэмэгдсэнтэй, төсвийн төсөл буурч батлагдсан нь тайлант онд цар тахалтай холбоотой хил онгоогүйтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн татвар хураалт, орлого бүрдүүлэлт хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 582.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 582.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 457.1 сая төгрөгийг зарцуулж 125.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 457.1 сая төгрөг буюу 78 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 53.8 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлын зүйл ангийг 20.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 50.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.9 тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хороо нь тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хороо нь 2021 онд нийт 823.6 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 48.2 сая төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн түүвэрлэн үзсэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.4 сая төгрөгийн 2 заалт зөрчлийг арилгах албан шаардлага 1 заалт хариуцлага оногдуулах албан шаардлага 2 заалт зөвлөмж хүргүүлснийг биелүүлсэн талаар албан бичиг нотлох баримт ирсэн боловч и-баримтын зөрчил давтагдан гарчээ.

Давтагдан гарсан зөрчил нь өмнөх онд зөвлөмж өгсөн зөрчил байх тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах заалтыг хэрэглээгүй албан шаардлага хүргүүлээ.

Цаашид аудитын дүн дүгнэлт, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх зохион байгуулалтын ажлыг оновчтой хэлбэрээр хийж Төрийн аудитын газрын гаргасан дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагад ач холбогдол өгч илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг онцлон дурдъя.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар автомашины ашиглалт, нярвын бүх төрлийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдлыг тус тус анхаарах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 98.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 48.7 сая төгрөгийн алдааг залруулж, 2.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 47.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар тайлант онд 29.6 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй, зардлын зүйл анги зөрчиж хийсэн 19.1 сая төгрөгийн гүйлгээ хийснийг илрүүлж аудитын хугацаанд нөхөн шивүүлж анхан шатны баримтын шаардлагыг хангуулсан, зардлын зүйл ангийг санхүүгийн тайланд залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Шатахууны тооцоог давтан хийхэд 0.9 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүйгээр зарцуулснаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тайлант онд 0.3 сая төгрөгийн зориулалт бусаар зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тус байгууллагад бичиг хэрэг архивын эрхлэгчийн 1 орон тоотой албан тушаалд 2 албан тушаалтан томилогдсон ба 1 албан тушаалтан нь бодитоор ажиллаагүй байхад ажилласан мэтээр цагийн бүртгэл хөтөлж 1,346.9 мянган төгрөгийн цалин олгосон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Тайлант онд 8.8 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ төлбөрийн баримтын нэгдсэн системийн баримтын жагсаалтын худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.1 сая төгрөгийн дутуу төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын данс бүртгэлд байдаг албаны DONGFENG маркийн 24 53 ГАА улсын дугаартай ус тээвэрлэдэг автомашины заалт спидометрийн заалт тайлант онд 9,100 километр буюу 6.9 сая төгрөгийн гүйлтээр тасарсан байхад хувийн хэрэгт тэмдэглэгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Хамгаалах хэрэгсэл нэрээр 2.4 сая төгрөг гаргасан боловч хүүхдийн баярын бэлэгт зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан

ажилтан хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Гэрэл цахилгааны зардлаас 1.9 сая төгрөгийн генераторын түлшний зардлыг мотор.цагийн зарцуулалтын тооцоогүйгээр зөвхөн шаардах хуудас үндэслэн зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-т "Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан бүтэц, орон тооноос гаалийн хяналт шалгалт хариуцсан улсын байцаагчийн орон тоог 1-ээр илүү ажиллуулсан нь Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/262 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 16.5.3-т "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Нийгмийн даатгалын хэлтэст 1,288.8 мянган төгрөгийн цалин илүү тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 1-т "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 2-т "Шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн албан шаардлага:

Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалан автомашинд гарсан гэмтэл 8.5 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөр засварласан, хуулийн байгууллагад байгууллагад бодит хохирол гараагүй гэсэн мэдүүлэг өгсөн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, зөрчлийн, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ" Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Чиг үүргийн биш ажил болох оношилгоонд зориулж хил нээгдээгүй байхад 6.5 сая төгрөгөөр ковид-19 өвчний түргэвчилсэн оношлуур худалдан авч тухайн сардаа бүрэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар Нийгмийн даатгалын тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. **2.1 Илрүүлэлт:** Тайлант онд Байгууллагын дарга нягтлан бодогч биеэр амраагүй, амралтын олговор аваагүй
- 1.2. **Өгсөн зөвлөмж:** Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, ЭМС нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1.3-т "Ажил олгогч нь бүх ажилтанг жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ" Хөдөлмөрийн тухай хуулийн 55.1.2-т "Ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно" гэсэн заалтыг хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хороо	15	98.8	2	48.7	3	2.5	9	47.5	1	